ТАВАНТОЛГОЙ ХК

# “ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН

# МАТЕРИАЛ

**Тавантолгой**

**2026 он**

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

"Тавантолгой" Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 13 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**"ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР**

**Компанийн нэр:** "Тавантолгой" ХК.

**Хурал хуралдах газар:** Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-Овоо 3 дугаар баг, Бор 2 дугаар гудамж 207 тоот хаягт байрлах "Тавантолгой" ХК-ийн төв байр, 2 давхрын хурлын танхим.

**Хурал хуралдах өдөр, цаг:** 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 10:00 цагт болно.

**Хурал зохион байгуулах хэлбэр:** Танхим.

**Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр:** 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдөр.

**Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд:**

1."Тавантолгой" ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай

2."Тавантолгой" ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

3."Тавантолгой" ХК-ийн 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай

4."Тавантолгой" ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай тайланг танилцуулах тухай

5.Төлөөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай

6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай

7.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай

Хувьцаа эзэмшигчид 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд дараах сувгуудаар болон компанийн өөрийн цахим хуудсаар дамжуулан хурлын материалтай танилцах боломжтой. Үүнд:

1.Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани.

2."Тавантолгой" ХК-ийн Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 20 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-36, "Монгол Савхи" ХК-ийн байр, 6 давхар 602 тоот

3."Тавантолгой" ХК-ийн оффис, Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-Овоо 3 дугаар баг, Бор 2 дугаар гудамж, 207 тоотод байрлах "Тавантолгой" ХК-ийн

төв байранд ирж хурал зохион байгуулах комиссын гишүүдэд мэдэгдэн хурлын баримт бичигтэй танилцах боломжтой.

Хуралд биечлэн оролцох боломжгүй Хувьцаа эзэмшигчдийг санал өгөх боломжоор хангах зорилгоор 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 16:00 цаг хүртэл доорх сувгуудаар дамжуулан урьдчилсан саналын хуудсыг хүлээн авна. Үүнд:

1.Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани.

2.“Тавантолгой” ХК-ийн Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 20 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-36, “Монгол Савхи” ХК-ийн байр, 6 давхар 602 тоот

3.“Тавантолгой” ХК-ийн оффис, хаяг: Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-Овоо 3 дугаар баг, Бор 2 дугаар гудамж 207 тоот.

4.Холбоо барих: 99074978, 88086686, 99010179.

5.И-мэйл хаяг: info@tavantolgoi.mn

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

## ХУРАЛ ЗАРЛАСАН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ТАВАНТОЛГОЙ ХК

**ӨМНӨГОВЬ АЙМАГ**
**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**
**ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 07 өдөр          Дугаар 13          Цогтцэций сум

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал**
**зарлан хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 65 дугаар зүйлийн 65.4, 65.5, 65.6 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Тавантолгой” Хувьцаат компанийн дүрмийн Зургаагийн 6.3, 6.5, 6.6 дахь хэсэг, Долоогийн 7.4.2, 7.4.3 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын Гурвын 3.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн “Тавантолгой” хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.“Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагт Өмнөговь аймгийн Цогтцэций сум, “Тавантолгой” ХК-ийн төв оффисын 2 давхрын хурлын танхимд хуралдуулсугай.

2."Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр, хурлын зарыг хоёрдугаар, хурлын дэгийг гуравдугаар, хуралтай холбоотой танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг дөрөвдүгээр, хуралд санал авах саналын хуудасны загварыг тавдугаар хавсралтаар тус тус батлагсугай.

3.“Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг холбогдох баримт бичгүүдийн хамт 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д тус тус хүргүүлсүгэй.

4.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөр тогтоосугай.

5.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Санхүүгийн зохицуулах хорооны баталсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу олон нийтэд зарласугай.

6.Тус тогтоолын хавсралтаар баталсан Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичгийн жагсаалтыг бэлэн болгож 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер дилерийн компаниудад хүргүүлсүгэй.

7.Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдэд саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 20 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-36, "Монгол Савхи" ХК-ийн байр, 6 давхар 602 тоот хаягт байрлах компанийн Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газар, Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-Овоо 3 дугаар баг, Бор 2 дугаар гудамж 207 тоот хаягт байрлах "Тавантолгой" ХК-ийн төв байр, компанийн оффис болон хувьцаа эзэмшигчийн үйлчлүүлдэг үнэт цаасны компаниар дамжуулан урьдчилсан саналын хуудсыг хүлээн авах ба саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 16:00 цаг байна.

8.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар "Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Бямбаагийн Мэндбаярыг сонгосугай.

9.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Мэндбаяр, гишүүдээр Гүйцэтгэх захирал Ш.Отгонбаяр, Захиргаа, удирдлагын газрын захирал С.Идэрсүрэн, Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн газрын захирал Б.Нарантуяа, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Бөхбат нарыг томилсугай.

10.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн Хөрөнгө оруулалтын албаны захирал С.Дэлгээн, гишүүдээр Захиргааны хэлтсийн Хуулийн ахлах мэргэжилтэн Б.Болдбаяр, Дотоод хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Сугиржав нарыг тус тус томилсугай.

11.Хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Санхүүгийн Зохицуулах Хороо, "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-д хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комиссын дарга (Б.Мэндбаяр)-д даалгасугай.

12.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссын баталсан төсвийн хүрээнд холбогдох зардлыг үйл ажиллагааны зардлаас зарцуулахыг Гүйцэтгэх захирал (Ш.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Б.МЭНДБАЯР

ТАВАНТОЛГОЙ ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

“Тавантолгой” Хувьцаат компанийн Төлөөлөн
удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 07-ны
өдрийн 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

## “ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

1.“Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай

2.“Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

3.“Тавантолгой” ХК-ийн 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай

4.”Тавантолгой” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай тайланг танилцуулах тухай

5.Төлөөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай

6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай

7.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

“Тавантолгой” Хувьцаат компанийн Төлөөлөн
удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 07-ны
өдрийн 13 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

## “ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хурал 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагт эхлэнэ.

| № | Хэлэлцэх асуудал | Хугацаа | Хариуцах этгээд |
|---|---|---|---|
| 1 | Хурлын ирцийг бүртгэх | 10:00-11:00 | Тооллогын комисс |
| 2 | Хурлын ирцийг хурлын дарга болон хуралд оролцогч нарт мэдээлэх | 11:00-11:10 | Тооллогын комисс |
| 3 | Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах | 11:10-11:20 | Хурлын дарга Б.Мэндбаяр |
| 4 | **Хурлаар хэлэлцэх асуудлууд** | | |
| | 1.“Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай | 11:20-11:40 | Гүйцэтгэх захирал Ш.Отгонбаяр |
| | 2.“Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай | 11:40-11:50 | Хурлын дарга Б.Мэндбаяр |
| | 3.“Тавантолгой” ХК-ийн 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай | 11:50-12:00 | Хурлын дарга Б.Мэндбаяр |
| | 4.”Тавантолгой” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай тайланг танилцуулах тухай | 12:00-12:05 | Хурлын дарга Б.Мэндбаяр |
| | 5.Төлөөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай | 12:05-12:20 | Хурлын дарга Б.Мэндбаяр |
| | 6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай | 12:20-12:30 | Хурлын дарга Б.Мэндбаяр |
| | 7.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай | 12:30-12:40 | Хурлын дарга Б.Мэндбаяр |
| 5 | Хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт, хариулт | 12:40-12:55 | Хурлын дарга Б.Мэндбаяр |
| 6 | Саналын хуудас бөглөх заавар танилцуулах | 12:55-13:05 | Тооллогын комисс |
| 7 | Саналын хуудсаар санал авах | 13:05-13:15 | Тооллогын комисс |
| 8 | Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналыг тоолж, нэгтгэх, боловсруулах | 13:15-13:30 | Тооллогын комисс |
| 9 | Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах | 13:30-13:40 | Тооллогын комисс |

| | | | |
|---|---|---|---|
| 10 | Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах | 13:40-13:50 | Хурлын дарга Б.Мэндбаяр |
| 11 | Хурлыг хаах | 13:50-14:00 | Хурлын дарга Б.Мэндбаяр |

Хурлын үргэлжлэх нийт хугацаа: 3 цаг 00 минут байна.
Шаардлагатай тохиолдолд хугацааг сунгаж болно.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

ТАВАНТОЛГОЙ ХК
УДИРДАХ ЗӨВЛӨЛ
АТА14355 2016555

"Тавантгой" Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 13 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

## "ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛТАЙ ХОЛБООТОЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 13 дугаар тогтоол.

2."Тавантолгой" ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан.

3."Тавантолгой" ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт.

4.2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг тараах эсэх тухай, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр.

5."Тавантолгой" ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай тайлан.

6.Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл.

8.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар.

Хувьцаа эзэмшигчдэд танилцуулах зорилгоор дээрх материалуудыг компанийн албан ёсны цахим хуудас болох www.tavantolgoi.mn хаягт байршуулсан тул тус цахим хуудсаар дамжуулан хурлын материалтай танилцахыг хүсэж байна.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

"Тавантолгой" Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 13 дугаар тогтоолын тавдугаар хавсралт

ТАВАНТОЛГОЙ ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
АТА14355 2016656

**"ТАВАНТОЛГОЙ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог .................................. нэр ....................................................
Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар
Регистрийн дугаар

Санал өгөх хувьцааны тоо .................................
Бүртгэсэн /Үнэт цаасны компани / .........................................
Брокерын овог .................................... нэр ...................................

*"Тавантолгой"" ХК-ийн **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал** 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагт Өмнөговь аймгийн Цогтцэций сум, "Тавантолгой" ХК-ийн байранд хуралдана.*

Саналын хуудас бөглөх заавар: **Дараах хэлэлцэх асуудлуудыг ЕРДИЙН АРГААР санал хураана.**

Ердийн аргаар саналаа өгөхөд асуудал бүрээр "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" аль нь болохыг тэмдэглэнэ.

| № | ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД | Хурлаас гарах шийдвэрийн төсөл | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн | Санал |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | "Тавантолгой" ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай | Тогтоол №1 | | | | |
| 2. | "Тавантолгой" ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай | Тогтоол №2 | | | | |
| 3. | "Тавантолгой" ХК-ийн 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай | Тогтоол №3 | | | | |
| 4. | "Тавантолгой" ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай тайланг танилцуулах тухай | Тогтоол №4 | | | | |
| 5. | Төлөөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай | Тогтоол №5 | | | | |
| 6. | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай | Тогтоол №7 | | | | |

Брокер: ............................................ / /
/гарын үсэг, тэмдэг/

Хувьцаа эзэмшигч: .............................. / /
/ гарын үсэг /

Саналын хуудсыг **хүчинтэйд** тооцов: ......................................./ /
Саналын хуудас **хүчингүйд** тооцсон бол шалтгаан:.............................................................................................
.......................................................................................................................................................

2026 оны ... сар ... өдөр

## "ТАВАНТОЛГОЙ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог .................................. нэр ......................................................

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Регистрийн дугаар

Эзэмшиж буй хувьцааны төрөл ............................. тоо ...................................

Кумулятив хувьцааны тоо: ................................................................

Бүртгэсэн /Үнэт цаасны компани / ..........................................

Брокерийн овог ..................................... нэр ......................................

*"Тавантолгой"" ХК-ийн* ***Хувьцаа эзэмшигчдийн ээлжит*** *2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагт Өмнөговь аймгийн Цогтцэций сум, "Тавантолгой" ХК-ийн байранд хуралдана.*

| 3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох | | | | |
|---|---|---|---|---|
| **ТУЗ-ийн ердийн гишүүн:** | | **Санал авах арга** | **Хурлаас гарах шийдвэрийн төсөл** | **Нэр дэвшигчид өгөх саналын тоо** |
| 1. | ........................................ | Кумулятив | Тогтоол №6 | |
| 2. | ........................................ | | | |
| 3. | ........................................ | | | |
| 4. | ........................................ | | | |
| 5. | ........................................ | | | |
| 6. | ........................................ | | | |
| **ТУЗ-ийн хараат бус гишүүн:** | | | | **Нэр дэвшигчид өгөх саналын тоо** |
| 1. | ........................................ | | | |
| 2. | ........................................ | | | |
| 3. | ........................................ | | | |

Брокер ............................................... Гарын үсэг

/тэмдэг/

Хувьцаа Эзэмшигч .............................. Гарын үсэг

2026 ....... сар.......өдөр

*Саналын хуудасны хүчинтэйд тооцон тоолсон Тооллогын Комиссын дарга* ..........................................................

*Комиссын Гишүүн* .........................................................

*Хүчингүйд тооцсон бол шалтгаан* ...........................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................

## САНАЛЫН ХУУДСЫГ БӨГЛӨХ САНАМЖ:

Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.

1. Саналыг ердийн аргаар тоолох асуудалд:

- Тухайн асуудалд зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн аль нэгд нь ✓ эсвэл + тэмдгээр санал аа өгнө.
- Засварласан, балласан, эсвэл болон аль нэг саналыг бөглөөгүй бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.

2. Саналыг кумулятив аргаар тоолох асуудалд:

- ТУЗ-ийн гишүүдэд санал өгөхдөө кумулятив аргаар санал хураана
- Хувьцааны нэгж тутамд ТУЗ-ийн гишүүнийг сонгох 1 саналын эрх байна. Хувьцаа эзэмшигч саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.

- Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.
- Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамаарна.

*Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт*

| **2025 оны жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/** | |
|---|---|
| *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл илгээж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.* | |
| *Тайлагналын хугацаа* | 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | "Тавантолгой" ХК<br>Регистрийн дугаар: 2016656<br>Улсын бүртгэлийн дугаар: 1110001005<br>Үнэт цаасны код: MN00TTL04580<br>Утас: 7535-5555, 9500-1619 |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Уул уурхайн олборлолт, борлуулалт |
| *Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо* | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар, Хэрэгжүүлэгч "Солид юнити аудит" ХХК |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 52,665,200 ширхэг |
| *Жилийн тайлагн бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | Төлөвлөлтийн эдийн засагч Ч.Тэрмандах<br>Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн газрын захирал Б.Нарантуяа |

| | | |
|---|---|---|
| *1.* | *Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/* | |
| | *Санхүүгийн байдлын үзүүлэлт* | Санхүүгийн тайлан хавсаргав. |
| | *Орлогын тайлан* | Санхүүгийн тайлан хавсаргав. |
| | *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | Санхүүгийн тайлан хавсаргав. |
| | *Мөнгөн гүйлгээний тайлан* | Санхүүгийн тайлан хавсаргав. |
| | | |
| *1.1.* | *Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт* | |

| | | |
|---|---|---|
| | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар, түүнийг хэрэгжүүлэгч “Солид юнити аудит” ХХК нь 2025 оны санхүүгийн тайланд хараат бус хөндлөнгийн аудит хийж байгаа бөгөөд санхүүгийн тайлан дахь аудитын дүгнэлт бүрэн гарч дуусаагүй болно. Дүгнэлт гарсны дараа дахин хүргүүлэх болно. | |
| 1.2. | *Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/* | |
| | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар, түүнийг хэрэгжүүлэгч “Солид юнити аудит” ХХК нь 2025 оны санхүүгийн тайланд хараат бус хөндлөнгийн аудит хийж байгаа бөгөөд санхүүгийн тайлан дахь аудитын дүгнэлт бүрэн гарч дуусаагүй болно. Дүгнэлт гарсны дараа дахин хүргүүлэх болно. | |
| 2. | *Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл* | |
| 2.1. | *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/* | Нийт ашгийн хувь 34.9%<br>Цэвэр ашгийн хувь 25.2%<br>Өөрийн хөрөнгийн өгөөж 61.0% |
| 2.2. | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт* | Эргэлтийн харьцаа 1.79<br>Түргэн хөрвөх чадварын харьцаа 1.09<br>Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа 1.05 |
| 2.3. | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь,бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт,хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл* | Нүүрсний зах зээлийн нөхцөл байдал улс төрийн болон гадаад орчны нөхцөл байдал, дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдалтай холбоотойгоор тогтвортой биш байгаа нь таамаг гаргахад хүндрэлтэй байна. Компанийн нүүрс экспортын үйл ажиллагаа нь Уул уурхайн биржийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу Монголын хөрөнгийн биржид 100% нээлттэй явагдаж байгаа. Өнгөрсөн жилийн байдлаар 54 удаагийн цахим арилжааг зарлаж 22 арилжаа буюу 40.7%-ийн амжилттайгаар нийт 5.3 сая.тн нүүрс худалдсан. Биржээр арилжаалсан нийт нүүрсний 24.61% эзэлж байна. Өнгөрсөн 2025 оны нөхцөл байдлыг авч үзэхэд: |

| | | |
|---|---|---|
| | | 1. Уурхайн үйл ажиллагаа 2-8-р сард буюу жилийн 56%-д сул зогсолттой, борлуулалт оны эхний хагасд 22.2%-тай ажилласан.<br>2. Төлөвлөсөн үнээс жигнэсэн дундаж үнэ 53.7$ буюу 37.4% бага борлуулсан.<br>3. 2024 оны 10 сараас хойш 2025 оны 06 сар хүртэл -83.4$ буюу -45.9% бууралт.<br>2026 онд нийт 6.7 сая.тн нүүрс экспортод борлуулж 1.8 их наяд төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллахаар төлөвлөж байгаа.<br>Борлуулалтын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр хилийн нэвтрүүлэх тоо хэмжээг нэмэгдүүлэх, нүүрсний арилжааг оновчтой зохион байгуулах, тээврийн олон чиглэлийг ашиглахаар төлөвлөсөн. Авто зам, төмөр зам, жолоочгүй ухаалаг тээврийг ашиглахаар төлөвлөсөн. Түүнчлэн дан ганц Гашуунсухайт боомтоор нийлүүлэлт хийх бус Ханги чиглэлд нүүрс экспортын үйл ажиллагааг явуулахаар төлөвлөн ажиллаж байна. |
| 2.4. | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл*<br>*/off balance/* | Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй. |
| 2.5. | *Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;* | Тайлант хугацаанд зээл аваагүй. |
| 3. | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* | |

| | |
|---|---|
| | Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгээгүй. |
| *4.* | *Цалин урамшууллын мэдээлэл* |
| | Компанийн батлагдсан бүтэц, орон тоо, бизнес төлөвлөгөөний дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн цалин, урамшууллыг олгож ажилласан. |
| *5.* | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* |
| | **ТУЗ-ийн хурал**<br>Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн "75.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна." гэж заасны дагуу Орон нутгийн өмчийн оролцоотой "Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2025 онд 91,8 хувийн дундаж ирцтэйгээр, нийт 31 удаа хуралдаж, 73 асуудал хэлэлцэн, 86 тогтоол батлан, гүйцэтгэх удирдлагад үүрэг чиглэл өгч хэрэгжүүлэн ажилласан байна. Зөвлөлийн хурлаас баталсан тогтоол шийдвэрийг бүтцээр нь авч үзвэл:<br>Удирдлага, зохион байгуулалт, бүтэц орон тооны чиглэлээр 18 тогтоол баталсан нь нийт тогтоолын 21 хувь, Ажлын хэсэг байгуулах чиглэлээр 6 тогтоол буюу  7.3 хувь, Компанийн үйл ажиллагааг дүгнэх чиглэлээр 2 тогтоол баталсан нь 2.4 хувь, Нүүрс, тээврийн үнэ, хэмжээ тогтоох чиглэлээр 13 тогтоол баталсан нь 13.4 хувь, Хэмнэлтийн горимд шилжүүлэх чиглэлээр 3 тогтоол баталсан нь 3.6 хувь, Төлөвлөгөө, журам батлах, төлөвлөгөөнд тодотгол хийх чиглэлээр 5 тогтоол баталсан нь 6.1 хувь, Зөвшөөрөл олгох чиглэлээр 16 тогтоол баталсан нь 19.5 хувь, Ногдол ашгийн чиглэлээр 1 тогтоол баталсан нь 1.2 хувь, Биржийн арилжааг дэмжих чиглэлээр 2 тогтоол баталсан нь 2.4 хувь, Чиглэл өгөх чиглэлээр 9 тогтоол баталсан нь 10.9 хувь, Урамшуулал, дэмжлэг олгох тухай 7 тогтоол баталсан нь 8.5 хувийг тус эзэлж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам, хороодын үйл ажиллагааны боловсруулан шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.<br>**ТУЗ-ийн хороод**<br>МХБ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 4 хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой. Хороодын үйл ажиллагааг "Компанийн дүрэм" болон "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам" - аар тус тус зохицуулдаг.<br>ТУЗ нь дараах байнгын хороодтой:<br>• Нэр дэвшүүлэх хороо,<br>• Аудитын хороо;<br>• Цалин, урамшууллын хороо. |

| | |
|---|---|
| | ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь аудитын хороонд ажиллахаар заасан байдаг. |
| *6.* | *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл* |
| | БНХАУ-ын Нүүрсний зах зээлийн нөхцөл байдал, улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалж нүүрсний үнэ 2025 оны 06 сарын 16-ны байдлаар 98.2ам.долларт хүрч 2024 оны 10 дугаар сараас хойш 83.4 ам.доллар буюу 45.9% буурсан. Дээрх нөхцөл байдалтай холбоотойгоор компанийн үндсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тайлант оны 2-8 дугаар сарын хугацаанд зогсоон, борлуулалтаас бусад газар хэлтсүүдийг 60%-ийн сул зогсолтод хамруулан хэмнэлтийн горимд ажилласан. 2025 оны бизнес төлөвлөгөөнд тусгасан нүүрс борлуулалтын жигнэсэн дундаж үнээс 53.7 ам.доллар буюу 37.4% бага үнээр борлуулсан үзүүлэлттэй гарсан. Тайлант оны хугацаанд Монголын хөрөнгийн бирж дээрх уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд нийт 54 удаагийн арилжааг зарласнаас 22 арилжаа буюу 40.7% нь амжилттай болсон. 2025 оны 08 дугаар сараас нүүрсний үнэ сэргэж 125-145 ам.долларын дундажтай болсон. 2025 оны эхний хагас жил биет хэмжээгээр нийт борлуулалтын 22.2% хувийг, сүүлийн хагаст 77.8%-ийг тус тус борлуулсан. |
| *7.* | *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/* |
| | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн байдлаар нийт  4030 хувьцаа эзэмшигчтэй байсан.<br>1. Орон нутгийн өмч - 51%<br>2. Ажнай корпораци ХХК – 19.78%<br>3. Шандас Импекс ХХК - 16.31% |
